

**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ
ИРГЭНИЙ НИСЭХИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАНИЛЦУУЛГА**

2025.02.15

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

ЗТЯ-ны ИНБЗГ-ын Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт болон үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

ИНБЗГ-ын үйл ажиллагааг 2024 оны жилийн эцсийн байдлаар Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайд, ТНБД-ын тушаалын биелэлт гэсэн 5 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **83.1%**-тай үнэлэгдлээ. /Хүснэгт 1/

Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. ИНБЗГ-ын 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, үйлчилгээний хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Нийт	Үүнээс							Биелэлтийн хувь
	100%	90%	70%	50%	30%	0%	Үнэлээгүй Хугацаа болоогүй	
74	45	8	8	9	4	-	-	85,8%

2.2. МУ-ын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний биелэлт дараах байдалтай байна.

Нийт заалт	Үүнээс						Хэрэгжих боломжгүй	Биелэлтийн хувь
	100%	90%	70%	50%	30%	0%		
5	1	-	-	-	4	-	-	44%

2.3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцыг дүгнэвэл:

Нийт заалт	Үүнээс						Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	

20	9	7	4	-	-	-	75,5%
----	---	---	---	---	---	---	-------

2.4. Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт:

Нийт заалт	Үүнээс						Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
23	16	5	2	-	-	-	87.4%

2.5. ТНБД-ын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт:

Нийт заалт	Үүнээс						Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
3	3	-	-	-	-	-	100%

Үнэлэлт, дүгнэлт

1. Төлөвлөлтийн байдал:

ИНБЗГ-ын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин, хэрэгжүүлэх хугацааг яамны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон бусад төлөвлөгөөтэй уялдуулан улирал бүрээр хүрэх боломжтой, бодитойгоор төлөвлөн ИНЕГ болон бусад нэгж, байгууллагуудын оролцох үүрэг, хариуцлагыг ялгаатай тодорхойлж, БТГ, ХШҮДАГ-аар гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг хянуулан батлуулсан байна.

Яамны 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 10 сард өөрчлөлт оруулж, иргэний нисэхийн салбарын 1 арга хэмжээг яамны төлөвлөгөөнөөс хассан боловч газрын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулаагүй тул энэхүү ажлын үнэлгээнд оруулсан болно.

Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 74 арга хэмжээний 58 буюу нийт ажлын 78.4%-ийг нь жилийн турш, 15 арга хэмжээ буюу 20.3%-ийг эхний хагас жилд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн байна.

2. Хэрэгжилтийн байдал:

1/ ИНБЗГ-ын 2024 оны жилийн эцсийн байдлаар үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайд, ТНБД-ын тушаалын биелэлт гэсэн 5 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **83.1%**-тай үнэлэгдлээ. Эдгээрээс Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт хамгийн бага буюу 44%-тай үнэлэгдсэн байна.

2/ ИНБЗГ-ийн Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 53 арга хэмжээ буюу 71,6% нь бүрэн хэрэгжсэн болон хэрэгжих шатанд, 17 арга хэмжээ буюу 23% нь хэрэгжээгүй буюу төлөвлөсөн үр дүнд хүрээгүй байна.

Зорилт тус бүрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувиар үнэлбэл:

№	Зорилтууд	Арга хэмжээ ний тоо	Хэрэгжилт
1	Зорилт 1. Олон улсын агаарын харилцааны хэлэлцээрийн төсөл үзэглэх, шинээр байгуулах, нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ	12	87.5%

2	Зорилт 2. Иргэний нисэхийн салбарын эрх зүйн орчныг шинэчилнэ.	11	81.8%
3	Зорилт 3. Олон улсын өнгөрөлтийн нислэг, транзит зорчигчийн тоог нэмэгдүүлж, шинээр агаарын хаалга нээж, нислэгийн шугам хуваарилна.	12	84.2%
4	Зорилт 4. Иргэний нисэхийн салбарын бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, улсын тусгай хэрэгцээний газар ашиглах асуудлыг зохион байгуулна.	7	70%
5	Зорилт 5. Иргэний нисэхийн салбарт хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлнэ.	15	82%
6	Зорилт 6. Иргэний нисэхийн тогтвортой, хүртээмжтэй үйлчилгээг үзүүлэхэд чиглэсэн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангана.	11	99.1%
7	Зорилт 7. Нислэгийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг хангуулах, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахтай холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтийг хангуулах.	4	95%
8	Зорилт 8. Ажил олгогчийн болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаална.	2	100%
Нийт		74	85.8%

Зорилт тус бүрийг хүрэх түвшингээр үзүүлбэл:

№	Зорилтууд	Хүрэх түвшин	Хэрэгжилт
1	Зорилт 1. Олон улсын агаарын харилцааны хэлэлцээрийн төсөл үзэглэх, шинээр байгуулах, нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ	Байгуулах хэлэлцээр-7 Үзэглэх хэлэлцээр-3	Байгуулсан-5 Үзэглэсэн-2
2	Зорилт 2. Иргэний нисэхийн салбарын эрх зүйн орчныг шинэчилнэ.	Батлуулах: журам-2 дүрэм-8, төлөвлөгөө-2 аргачлал-1 стандарт-1	Батлуулсан: журам-0 дүрэм-6 төлөвлөгөө-1 аргачлал-1 стандарт-1
3	Зорилт 3. Олон улсын өнгөрөлтийн нислэг, транзит зорчигчийн тоог нэмэгдүүлж, шинээр агаарын хаалга нээж, нислэгийн шугам хуваарилна.	Өнгөрөлтийн нислэг 20%, транзит зорчигч 10%, агаарын хөлгийн тоог 4-өөр тус тус нэмэгдүүлсэн байна.	Өнгөрөлтийн нислэгийн өсөлт-60% /өмнөх оны мөн үетэй харьцуулсан тоо/ Транзит зорчигчдын өсөлт-18,1% /өмнөх оны мөн үетэй харьцуулсан тоо/ Шинээр нэмэгдсэн агаарын хөлгийн тоо-8 /2/
4	Зорилт 4. Иргэний нисэхийн салбарын бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, улсын тусгай хэрэгцээний газар ашиглах асуудлыг зохион байгуулна.	Иргэний нисэхийн салбарын бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, улсын тусгай хэрэгцээний газар ашиглах асуудлыг зохион байгуулсан байна.	Бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээнүүдийн хэрэгжилт хугацаа хоцролттой. Газар ашиглах асуудлыг зохицуулах ажлууд төлөвлөгөөний дагуу явж байна.
5	Зорилт 5. Иргэний нисэхийн салбарт хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлнэ.	Иргэний нисэхийн салбарт хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлсэн байна.	Хангалтгүй. Хөрөнгө оруулалт, санхүүжилт шийдвэрлүүлэх, улсын төсөвт тусгуулахаар СЯ, гадаадын хөрөнгө оруулагчид, хандивлагч байгууллагуудад саналаа хүргүүлэн ажилласан.
6	Зорилт 6. Иргэний нисэхийн тогтвортой, хүртээмжтэй үйлчилгээг үзүүлэхэд чиглэсэн	Зөвлөл, ТӨХК, ТӨХХК, ТХН, агаарын тээвэрлэгчдийн үйл	Зөвлөл, ТӨХК, ТӨХХК, ТХН, агаарын тээвэрлэгчдийн үйл

	бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангана.	ажиллагаанд тухай бүрд дэмжлэг үзүүлсэн байна.	ажиллагаанд дэмжлэг үзүүлэх ажил хэвийн, төлөвлөгөөний дагуу явагдаж байна.
7	Зорилт 7. Нислэгийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг хангуулах, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахтай холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтийг хангуулах.	Олон улсын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд нисэхийн аюулгүй ажиллагааг хангуулах арга хэмжээ авсан байна.	“Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны үндэсний журам, төлөвлөгөө батлах ажил хугацаа хоцорч байна.
8	Зорилт 8. Ажил олгогчийн болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаална.	Талуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалсан байна.	Хэвийн

2/ ИНБЗГ-ын 2023 он, 2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн өгсөн дараах зөвлөмжүүдийн хэрэгжилт ахисан байна.

Үүнд:

- Протокол, конвенцуудад нэгдэн орох бэлтгэл ажлыг хангуулах, Агаарын хөлөг, шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх журам батлуулах, Агаарын зайн зохион байгуулалтыг сайжруулж, агаарын замыг шинэчлэн тогтоох, “Буянт-Ухаа” олон улсын нисэх буудлыг засварын төв, сургалтын төвийн зориулалтаар ашиглах төсөл боловсруулж, хөрөнгө оруулагчдад хүргүүлэх зэрэг хөрөнгө санхүүжилт шаардагдахгүй шийдвэрлэх боломжтой ажлуудыг эрчимжүүлэх;
- ЗТХ-ийн сайдын 2023.04.23-ны өдрийн 02 дугаар албан даалгавраар Зам, тээврийн салбарын хэмжээнд 2023-2025 онд “Монголд зочлох жил”-ын хүрээнд аялал жуулчлалын дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх үүрэг өгсөний дагуу 2024 онд орон нутгийн нисэх буудлуудын үйл ажиллагаа, тохижилтыг сайжруулж, шинэ үйлчилгээ нэвтрүүлэх, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх тодорхой ажил төлөвлөн дэс дараатай арга хэмжээ авах;
- БТГ, ТЗУГ, ХШҮДАГ-тай хамтран Иргэний нисэхийн харьяа байгууллагууд ялангуяа төрийн өмчит компаниудын ашиг орлогыг нэмэгдүүлэх, хүний нөөцийг бэхжүүлэх, аюулгүй ажиллагааг хангах шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулан батлуулж, үйл ажиллагааг үнэлэн дүгнэх, хариуцлага тооцох зохицуулалтыг бий болгох;

3/ Дараах зөвлөмжүүд хэрэгжээгүй, удаашралтай хэвээр байна. Үүнд:

- Концессын зүйлийн жагсаалтад тусгуулсан орон нутгийн нисэх буудлуудыг өргөтгөх, хүчин чадлыг сайжруулах төсөл, арга хэмжээнүүдийн сонгон шалгаруулалтыг 2024 оны I улиралд багтаан хийж, хэрэгжүүлж эхлэх;
- “Өндөрхаан нисэх онгоцны буудлыг шинэчлэн барих төсөл”-ийг хэрэгжүүлж дуусгах, “Дэлүүн болдог” нисэх буудлын барилгын ажил, “Өлгий” нисэх буудлын өргөтгөлийн барилгын ажлыг хэрэгжүүлэх, Бүсийн нислэгийн хөдөлгөөний төвийн барилгын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулах зэрэг бүтээн байгуулалтын ажлуудыг удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллах;
- Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2025 оноос хэрэгжиж эхлэхтэй холбоотойгоор энэхүү хуультай уялдуулан батлуулахаар хүлээгдэж байгаа дүрэм журмуудыг боловсруулж дуусгах, ИНЕГ болон ИНҮТ-ийн бүтэц орон тоог хууль тогтоомжид нийцүүлэн оновчтой боловсруулж, шинэчлэн батлуулах, агентлагийн албан хаагчдыг төрийн албан хаагч болгох, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулах ажлуудын бэлтгэлийг бүрэн хангуулах,
- БНХАУ (Эрээн-Мөрөн), Вьетнам (Хошимин), ОХУ (Новосибирск)-тай шинэ чиглэлд шууд нислэг эхлүүлэх, “Буянт-Ухаа” олон улсын нисэх буудлаас орон

нутгийн зарим хуваарьт нислэгийг үйлдэх ажлуудын гэрээ, хэлцлийг эрчимжүүлэх;

- “Өндөрхаан нисэх онгоцны буудлыг шинэчлэн барих төсөл”-ийг хэрэгжүүлж дуусгах, “Дэлүүн болдог” нисэх буудлын барилгын ажил, “Өлгий” нисэх буудлын өргөтгөлийн барилгын ажлыг хэрэгжүүлэх, Бүсийн нислэгийн хөдөлгөөний төвийн барилгын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулах, “Чингис хаан” олон улсын нисэх буудалд “Шатахуун хангамжийн байгууламж”, “Транзит зочид буудал” байгуулах ажлыг эхлүүлэх, Ховдын Булган, Хэнтий Дадал сумын нисэх буудлын аэродромын их засвар зэрэг бүтээн байгуулалтын ажлуудыг удирдлага зохион байгуулалтаар ханган 2024 онд багтаан дуусгах;

Дөрөв. Санал, зөвлөмж

1. Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2025 оноос хэрэгжиж эхлэхтэй холбоотойгоор энэхүү хуультай уялдуулан батлуулахаар хүлээгдэж байгаа дүрэм журмуудыг боловсруулж дуусгах, ИНЕГ болон ИНҮТ-ийн бүтэц орон тоог хууль тогтоомжид нийцүүлэн оновчтой боловсруулж, шинэчлэн батлуулах, агентлагийн албан хаагчдыг төрийн албан хаагч болгох, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулах ажлуудын бэлтгэлийг бүрэн хангуулах,
2. Концессын зүйлийн жагсаалтад тусгуулсан орон нутгийн нисэх буудлуудыг өргөтгөх, хүчин чадлыг сайжруулах төсөл, арга хэмжээнүүдийн сонгон шалгаруулалтыг эрчимжүүлэх, ТЭЗҮ-ийн үндэслэлийг боловсруулж сонгон шалгаруулалтыг зарлах чиглэлээр ЭЗХЯ-тай хамтран ажиллах;
3. БНХАУ-тай шинээр агаарын хаалга нээх яриа хэлэлцээг эрчимжүүлэх, Агаарын харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах, үзэглэх, нэмэлт өөрчлөлт оруулах, Иргэний нисэхийн ерөнхий газрын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг батлуулах зэрэг хөрөнгө санхүүжилт шаардагдахгүй ажлуудыг эрчимжүүлэх
4. “Өндөрхаан нисэх онгоцны буудлыг шинэчлэн барих төсөл”-ийг хэрэгжүүлж дуусгах, “Дэлүүн болдог” нисэх буудлын барилгын ажил, “Өлгий” нисэх буудлын өргөтгөлийн барилгын ажлыг хэрэгжүүлэх, Бүсийн нислэгийн хөдөлгөөний төвийн барилгын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулах, “Чингис хаан” олон улсын нисэх буудалд “Шатахуун хангамжийн байгууламж”, “Транзит зочид буудал” байгуулах ажлыг эхлүүлэх, Ховдын Булган, Хэнтий Дадал сумын нисэх буудлын аэродромын их засвар зэрэг бүтээн байгуулалтын ажлуудыг удирдлага зохион байгуулалтаар ханган 2025 оны эхний хагас жилд багтаан дуусгах;
5. ИНБЗГ-ын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа дараах чиглэлийг баримтлан ажиллах. Үүнд:
 - Тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд ИНЕГ болон бусад нэгж, байгууллагуудын оролцох үүрэг, хариуцлагыг ялгаатай тодорхойлох.
 - Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин, хэрэгжүүлэх хугацааг яамны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон бусад төлөвлөгөөтэй уялдуулан улирал бүрээр хүрэх боломжтой, бодитойгоор төлөвлөх.
 - 2024 онд хэрэгжүүлж дуусаагүй болон бодлогын бичиг баримт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрт туссан төсөл, арга хэмжээнүүдийг бүрэн хамруулах.
 - БТГ, ХШҮДАГ-аар гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг хянуулах.

6. Холбогдох тайлан, мэдээлэл ялангуяа бодлогын бичиг баримтууд, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтээ хугацаанд нь бүрэн тайлагнахад онцгой анхаарч ажиллах;

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР